



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан найман аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан хоёр иргэн, аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан таван иргэн, аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын тавдугаар хавсралтад дурдсан хоёр иргэн, аж ахуйн нэгжийн амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын 23
өдрийн 172 тоот тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Мандухай ХХК	Мандухай	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 3

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын 23
өдрийн АТД-от тушаалын хоёрдугаар
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Наран саран ХХК	Рич филд	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу
2	Атар шим трейд ХХК	Морин хуур	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж 10
3	Атар шим трейд ХХК	Тэргэл-1	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Б.Доржийн гудамж 11
4	Атар шим трейд ХХК	Тэргэл-2	Баянгол дүүрэг, 7-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө 65/5
5	Атар шим трейд ХХК	Тэргэл-3	Баянгол дүүрэг, 9-р хороо, Хасбаатарын гудамж 25/2
6	Оюуны аав ХХК	Агора	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Улаан хуарангийн гудамж 80
7	Мөнх Ариун ундарга ХХК	Сац	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Шаравын гудамж, Үйлдвэр 12
8	Стар интер трейд ХХК	АСЕ	Баянгол дүүрэг, 7-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө 43

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 20.15 онь 07 сарын 23
өдрийн 17:27 боот тушаалын гуравдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Дулаан дэм ХХК	Лакшири	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Жаргалан хотхоны 4/7
2	Иргэн Г.Идэрзориг	Говь	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Доржийн гудамж 4

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын 23
өдрийн 1926 тоот тушаалын дөрөвдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Наян тул ХХК	Файне	Баянгол дүүрэг, 14-р хороо, 17/3 тоот
2	Ева центр ХХК	Ион	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Их тойруу 190
3	Иргэн А.Эрдэнэчимэг	Такара	Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүн нарангийн 18/30
4	Иргэн Б.Эрдэмсайхан	Жава	Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 13-р хороолол, Оюутны хотхон 68/1
5	Иргэн С.Золчимэг	Жоё	Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Нарны зам 13/1, 29

-00000-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 20.15-оны 07 сарын 2.3
өдрийн 17:00-оо тушаалын тавдугаар
хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2015.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Их хайрхан тур ХХК	Их хайрхан	Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт тосгон
2	Жасинт ХХК	Нестли даун	Чингэлтэй дүүрэг, 17-р хороо, Чингэлтэйн гудамж 39

-ооОоо-